

Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр”-ийн Солилцох ноот бичигт гарын үсэг зурах ёслолын арга хэмжээ

Элчин сайдын мэндчилгээ

(Хэзээ: 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдөр 13:00 цагаас, Хаана: Сангийн яам)

Монгол улсын Сангийн сайд, Эрхэмсэг ноён Ч. Хүрэлбаатар, Эрхэмсэг ноёд, хатагтай нараа. Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Дөнгөж сая Сангийн сайд Ч. Хүрэлбаатарын хамт Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр”-ийн Солилцох ноот бичигт гарын үсэг зурсандаа туйлын их баяртай байна.

Та бүхэн мэдэж байгаачлан, Япон улс Монгол улсад Хөгжлийн албан ёсны тусламжийг олон салбарт бусад улс орноос түрүүлж идэвхтэй хэрэгжүүлж ирсэн бөгөөд уг тусламж дэмжлэгийн гол цөм нь “Хүний нөөцийг хөгжүүлэх” чиглэл байсаар ирлээ.

Өнөөг хүртэл Улаанбаатар хотыг голчилсон 50 гаруй бага, дунд сургуулийн барилга барьж байгуулсныг та бүхэн мэдэж байгаа байх, мөн одоо байгаль орчинд ээлтэй, гамшигт тэсвэртэй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах боломжтой зэрэг олон улсын стандартад нийцсэн 4 жишиг сургуулийн барилгыг шинээр барьж байна.

Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр болон бусад олон хэлбэрээр оюутнууд хүлээн авч, одоогийн байдлаар 2000 гаруй монгол оюутан Японд суралцаж байна.

Тэдгээр оюутан, залуус нутагтаа буцаж ирсний дараа Засгийн газар, хувийн хэвшил зэрэг олон салбарт үр бүтээлтэй ажиллаж байгааг харахад туйлын их баяртай байдаг бөгөөд мөн эдгээр чадварлаг залуус Япон, Монголын харилцааг хөгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэж буйд талархаж байна.

Мөн сүүлийн жилүүдэд инженер, технологийн дээд боловсрол олгох 1000 инженерийн төсөл хэрэгжиж эхэлсэн ба, Японд суралцах замаар үйлдвэрлэлийн салбарын өндөр мэдлэг, мэргэжил бүхий Монголын аж үйлдвэрийн салбарын боловсон хүчин бэлтгэхийг зорьж байна.

Өнөөдөр ийнхүү үзэглээд буй “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр” нь сүүлийн 18 жилийн хугацаанд Монгол улсын 300 залуу төрийн албан хаагчид

Япон улсын их, дээд сургуулийн магистр, докторын хөтөлбөрт суралцах боломж олгож, Монголд улсын төрийн байгууллагын технократыг хөгжүүлэхэд хувь нэмэрээ оруулж ирлээ.

Ийнхүү гарын үсэг зурснаар шинээр 22 залуу төрийн албан хаагч Япон улсад суралцах ба эдгээр залуу боловсон хүчин эх орондоо буцаж ирсний дараа Япон улсад эзэмшсэн мэргэжил мэдлэгээ ашиглан Монгол улсын хөгжлийн төлөө амжилт гаргана хэмээн найдаж, энэхүү мэндчилгээгээ өндөрлөө.

Анхаарал тавьсанд баярлалаа.